



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2017 оны 04 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын тамгын газар /цаашид "Талууд" гэх/ хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлд хамтран ажиллахад энэхүү санамж бичгийн зорилго оршино.

Хоёр. Байгууллага хоорондын хамтын ажиллагаа

2.1. Талууд дараах үйл ажиллагаанд хамтран ажиллана:

2.1.1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад тусламж, дэмжлэг үзүүлэх

2.1.2.Тохижилт, цэцэрлэгжилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

2.1.3.Хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх

2.1.4.Орлого төвлөрүүлэхэд хуулийн хүрээнд хамтарч ажиллах

2.2. Талууд энэхүү санамж бичгийн зорилгыг хангахын тулд бүх шатанд ил тод, нээлттэй, багаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Хан-Уул дүүргийн Засаг дарга нь:

3.1.1.Гадаадын иргэн, харьяатын газрын хууль ёсны үйл ажиллагааг дэмжих

3.1.2.Хамтран гүйцэтгэж буй аливаа ажлыг хууль тогтоомжийн дагуу тогтоосон цаг хугацаанд гүйцэтгэх

3.1.3.Гадаадын иргэн, харьяатын газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх

3.1.4.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлахад хурлын танхим, бусад боломжоор туслах

3.1.5.Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах эд зүйл, техник хэрэгслийг худалдан авахад хөрөнгө оруулах

3.1.6. Санамж бичгийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн актыг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд уламжилж шийдвэр гаргуулах;

3.2. Гадаадын иргэн, харъяатын газар нь:

3.2.1. Засаг даргын хууль ёсны үйл ажиллагааг дэмжих

3.2.2. Орон нутгийн татварын болон татварын бус орлогыг төвлөрүүлэхэд хамтарч ажиллах

3.2.3. Бүх нийтийн их цэвэрлэгээ, мод тарих, ногоон байгууламж бий болгоход өөрийн ажилтан, албан хаагчдыг оролцуулах

3.2.4. Дүүргийн төрийн албан хаагчид болон иргэдийг гадаад улсад урт, богино хугацаагаар явахад дэмжлэг үзүүлэх;

Дөрөв. Бусад

4.1. Талууд энэхүү санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа харилцан зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд энэ нь бичгээр баталгаажуулж, талуудын эрх бүхий этгээдийн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.2. Талууд санамж бичгийн хүрээнд гүйцэтгэж буй ажилтай холбоотой аливаа асуудал, маргаан, үл ойлголцлыг хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, итгэлцлийг эрхэмлэн хэлэлцээний зарчмаар шийдвэрлэж байна.

САНАМЖ БИЧГИЙГ БАЙГУУЛСАН:


ГАДААДЫН ИРГЭН,

ХАРЪЯАТЫН ГАЗАР


Д.МӨРӨН

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН

ЗАСАГ ДАРГА


Ж.АЛДАРЖАВХЛАН